



**МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

Арцатын 624, 23 дугаар хороо,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17100
Утас: 26 61 71, Цахим шуудан: contact@met.gov.mn,
Цахим хуудас: www.met.gov.mn

2024.03.07 № 03/1094
танай _____-ны № _____-т

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ**


"2024 оны эхний хагас жилд хэрэгжилтийг эрчимжүүлэх төсөл арга, хэмжээний тухай" Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 01 дугаартай албан даалгаврын биелэлтийг хангуулах зорилгоор "Орчны бохирдлыг бууруулах, хуулийн хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэх" Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны 02 дугаартай албан даалгавар гарсан.

Албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг аймаг, нийслэл, сум, дүүрэг, сав газруудын хэмжээнд зохион байгуулж, сар бүрийн 25-ны өдрийн дотор тухайн сард авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг, 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор нэгдсэн тайланг тус тус ирүүлнэ үү.

Хувийг, Сав газрын захиргаадад.

Хавсралт 2 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


С.ЦОГТГЭРЭЛ

152401281



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН АЛБАН ДААЛГАВАР

2024 оны 08 сарын 01 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Орчны бохирдлыг бууруулах, хуулийн
хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэх талаар

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 1 дэх заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1, 9.1.4, 9.1.5 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, Усны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3, 12 дугаар зүйлийн 12.1.4, 13 дугаар зүйлийн 13.1.6, 17 дугаар зүйлийн 17.1.3, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.3 дахь заалтыг үндэслэн усны нөөцийг бохирдож, хомстохоос хамгаалах, урьдчилан сэргийлэх, хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажлыг орон даяар эрчимжүүлэх, иргэдийн хог хаягдлын талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор Бүх шатны Засаг дарга, Сав газрын захиргаадын дарга нарт ДААЛГАХ нь:

Нэг. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт:

1.1. Сум, дүүргийн харьяалах нутаг дэвсгэрт хорогдсон мал, амьтны сэг зэмийг устгах, мал эмнэлгийн халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулах;

1.2. Харьяалах нутаг дэвсгэрт усны сан бүхий газар, түүний хамгаалалтын бүсүүдэд давхцалтай хог хаягдлын төвлөрсөн цэгүүдийг нүүлгэн шилжүүлэх, нөхөн сэргээх, цэвэрлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллах;

1.3. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг бодитоор тогтоох, мөн олон нийтийн байцаагч ажиллуулах, урамшууллын журмыг Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулах;

1.4. Сумын төвүүдэд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, нягтруулах тоног төхөөрөмж бүхий дахивар авах төвүүдийг байгуулах ажлыг үе шаттайгаар шийдвэрлэх, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, булшлахад үйл ажиллагаанд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж зарим ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэх, дахин боловсруулах үйлдвэрүүд рүү шилжүүлэх ажлыг зохион байгуулах;

1.5. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, дахин ашиглах, дахин боловсруулах цогц менежментийг сумдад нэвтрүүлэх;

1.6. Сумын төвүүдийн хог хаягдлын төвлөрсөн цэгүүдийг эзэнжүүлэх, хашаажуулах ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулах;

152400 04

1.7.Урин дулааны улирал эхэлж байгаатай холбогдуулан шар усны үерээс хамгаалах, гэр хорооллын бүсийн гудамж талбай, усан сан бүхий газрын эрүүл ахуйн хамгаалалтын бүсэд болон автозамын дагуух хуримтлагдсан хог хаягдлыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулж, бүх нийтийн цэвэрлэгээг сар тутам зохион байгуулах;

1.8.Нутаг дэвсгэрийн хэмжээнд ил задгай хог хаягдал үүсгэхгүй байх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах.

Хоёр.Сав газрын захиргааны дарга нарт

2.1.Усны нөөцийг бохирдож, хомстохоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, түүний хамгаалалтын бүсэд давхцалтай хог хаягдлын цэгүүдийг нарийвчлан зураглах, нүүлгэн шилжүүлэх, цэвэрлэх, бохирдсон газрыг саармагжуулах чиглэлээр аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарыг мэргэжлийн зөвлөмжөөр хангаж, хамтран ажиллах;

2.2.Гол мөрний сав дахь цас, мөс хайлж, хаврын шар усны үер цөн түрэлттэй давхцан ус эргээсээ халих, голын эргийн татам усанд автах, өвөлжилт хүндэрсэн газруудын гуу жалганд хаягдсан мал, амьтны сэг зэм цасны усаар дамжин ус бохирдуулах болон өвчин эмгэг тараах аюултай тул холбогдох байгууллагатай хамтран зохих арга хэмжээг цаг алдалгүй авч цэвэрлэгээ устгал хийх, ард иргэд хаврын шар усны үер болон мөс цөмрөх аюулаас сэрэмжтэй байхыг онцгойлон анхааруулах арга хэмжээг авах.

Гурав.Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах чиглэлээр:

3.1.Энэхүү албан даалгаврын хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулан, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, нэгдсэн биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд ирүүлэхийг аймаг, Нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.2.Тус албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Салбарын хяналтын газарт, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газар, Хүрээлэн буй орчны бодлого зохицуулалтын газарт тус тус үүрэг болгосугай.

Б.Бат-Эрдэнэ

Б.БАТ-ЭРДЭНЭ